

Уул уурхай болон байгаль орчны зөвлөгөө

Аргуплан ХХК нь ХБНГУ-ийн баруун өмнөд зүгийн Карлсрүэ хотод байрладаг бөгөөд уул уурхайн бүх төрлийн төслүүд, байгаль орчны төлөвлөлт мөн маркшейдерийн хэмжилт зураглал хийх гэх зэрэг төслүүд дээр голчлон ажилладаг. Тус компани нь маркшейдер, уул уурхай, байгалийн шинжлэх ухааны чиглэлээр мэргэшсэн чадварлаг инженер техникийн ажилчдаас бүрддэг.

Уул уурхайн төслүүдийн төлөвлөлт

Аргуплан ХХК нь уул уурхайн төлөвлөлтийн бүх төрлийн ажиллагааг гадаад болон дотоодын далд болон ил уурхайн компаниудтай хамтран явуулдаг. Ингэхдээ эдгээр хувийн хэвшлийн болон улсын байгууллагуудын зүгээс тавьсан саналын дагуу төслийн гол санааг гаргахаас эхлэн бүх талын зөвлөгөө өгч тухайн төсөлд шаардлагатай үнэлгээ болон түүнд тохирох бүх үйл явцыг удирдан явуулдаг. Өөрөөр хэлбэл манай компани нь төслийн санаанаас эхлээд тухайн төслийн амжилттай хэрэгжиж дуусах хүртлэх хугацааг хамтран ажилладаг.

Байгаль орчны төлөвлөлт

Уул уурхайн бүх төслүүд нь үргэлж байгаль орчин болон байгаль орчны хамгаалал, нөхөн сэргээлтийн асуудлууд байнга дагалдаж байдаг. Энэ тал дээр ч аргуплан ХХК доорхи чиглэлийн байгууллагуудтай хамтран ажилладаг.

Тухайлбал :

- Ургамал, ан амьтан
- Агаар орчин
- Ус
- Хөрс

Зэрэгт үзүүлэх нөлөөллийн судалгаа болон үнэлгээг мэргэжлийн түвшинд хийж боловсруулдаг.



Инженерийн хэмжил зүй буюу Маркшейдерийн ажиллагаа

Аргуплан ХХК нь ил, далд уурхайн олборлолтын үйл ажилгааны хэмжил зүйн ажил дээр мэргэшсэн билээ. Захиалгат ажлын хүрээнд сансрын зураг дээрх хэмжилт, лазерсканерийн, ЖиПиЭс болон зайн хэмжилтийн аргуудаас тухайн нөхцөлд тохируулан сонгон авч ажилладаг.

Аргуплан ХХК нь олон улсын төслүүдийнхээ хүрээнд уул уурхайг сайжруулах чиглэлээр 2011 оны 5 сараас Шинжлэх Ухаан Технологийн Их Сургууль болон Оствэстфалэний Дээд сургуулиудтай хамтран, Монгол улсын уул уурхайн эдэлбэр газрыг зайнаас тандах судалгааны аргаар ялгаж таних, үүн дээрээ экологийн үнэлгээг хийх төслийг хэрэгжүүлж байна. Мөн ХБНГУ-ын уул уурхай, газар зүй хариуцсан удирдах газар, Монголын байгаль орчны яам, уул уурхайн удирдах газар, Монголросцветмент компани болон бусад байгууллагуудтай хамтран ажиллаж байна.

Харилцах хүн:

Ёорг Фүгманн
Маркшейдер, захирал

аргуплан ХХК
Форхолцштрасэ 7
D-76137 Карлсрүэ
ХБНГУ

Утас. +49-721-16110-16
Факс +49-721-16110-10
Гар утас. +49-175-5684899

www.arguplan.de
fugmann@arguplan.de

Jörg Fugmann
Markscheider Dipl.-Ing.

arguplan GmbH
Vorholzstrasse 7
D-76137 Karlsruhe
Tel: +49-721-16110-16
Fax: +49-721-16110-10
mobil: +49-175-5684899

